**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН**
**2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ**

Тайланг хянасан: Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ ........................................./Д.ДАВААНЯМ/

(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг ................
(огноо)

Тайлан гаргасан: Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА................................................./Г.ЧҮЛТЭМЖАМЦ/

(албан тушаал) (гарын үсэг)

Тэмдэг .....................
(огноо)

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|
| ЗОРИЛГО.БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ<br>/"Алсын хараа-2050" зорилт 5.3, "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн 5.3, "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр", "Улсын бүртгэлийн байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөө", УБЕГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө | | | | | | |
| ЗОРИЛТ 1. ДЭВШИЛТЭД ТЕХНОЛОГИД СУУРИЛСАН ТӨРИЙН ЦАХИМ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА БАЙНА. | | | | | | |
| 1.1 | Улсын бүртгэлийн Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр контент бэлтгэж түгээх | Сурталчилсан хэвлэл, мэдээллийн хэрэгслийн төрөл: | 3 | 3 | Улсын бүртгэлийн Зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг сурталчлах, соён гэгээрүүлэх чиглэлээр 3 контентийг бүтээж Хэлтсийн пэйж хуудсанд байршуулж олон нийтэд түгээлээ. | |
| | | Сурталчилсан мэдээ мэдээлэл, сурталчилгаа контентын тоо: | 3 | 3 | | |
| 1.2 | Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлэх | Улсын бүртгэлийн үйлчилгээг цахим машинаар /Киоск/ үзүүлсэн үйлчилгээний тоо ; | 450 | 1000 | 2025 онд Киоск машинаар лавлагаа-4477, тоон гарын үсэг олгох-7010 үйлчилгээг тус тус үзүүлж, пос төхөөрөмжөөр төлбөр төлөх үйлчилгээг 2780 иргэн авсан байна. | |
| 1.3 | Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээ хийх | Бүртгэлийн үйлчилгээнд дүн шинжилгээ хийсэн тоо; | 4 | 4 | Улсын бүртгэлийн үйлчилгээнд өгөгдлийн шинжилгээг 4 удаа хийж, бүртгэгчдийн ажлын ачааллын талаархи мэдээллийг албан хаагчдад хүргүүлж үүрэг чиглэл өгсөн. | |
| 1.4 | Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хувь: | 100 | 100 | 2025 оны 11.10-ны байдлаар Шилэн дансны тухай хуулийн дагуу https://info.shilendans.gov.mn/ цахим | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Тайлагнаж байршуулсан мэдээллийн тоо: | 171 | 171 | хуудсанд 143 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бөгөөд хугацаа хоцорсон, огт оруулаагүй мэдээлэл байхгүй. | |
| ЗОРИЛТ 2. ОРЧИН ҮЕИЙН ШИНЭ ТЕХНИК, ТЕХНОЛОГИ, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙГ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА НЭВТРҮҮЛЖ, ТӨРӨӨС ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ҮЗҮҮЛЭХ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХҮРТЭЭМЖ, ШУУРХАЙ БАЙДЛЫГ НЭМЭГДҮҮЛНЭ. | | | | | | |
| 2.1 | "Улсын бүртгэлийн үйлчилгээний төв болон цэг"-ийн үзүүлж байгаа үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх | Улсын бүртгэлийн зөөврийн тоног төхөөрөмжөөр үзүүлсэн үйлчилгээний тоо; | 300 | 800 | Улсын бүртгэлийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд хөдөөгийн малчдад газар дээр нь очиж бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх арга хэмжээг 2 удаа зохион байгуулж, 225 иргэнд тоон гарын үсэг олгон, 82 иргэнд иргэн, эд хөрөнгө,хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүллээ. | |
| 2.2 | Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу эрхлэн хөтлөх | Иргэний улсын бүртгэл хөтөлсөн хувь ; | 100 | 100 | Тайлант онд Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 11200, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 514, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 3618 бүртгэлийг улсын бүртгэлийн хууль тогтоомж, холбогдох журмын дагуу бүртгэсэн байна. | |
| | | Хуулийн этгээдийн улсын бүртгэл хөтөлсөн хувь; | 100 | 100 | | |
| | | Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл хөтөлсөн хувь; | 100 | 100 | | |
| 2.3 | E-mongolia төрийн үйлчилгээний системээр улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэх | E-Mongolia цахим системээр улсын бүртгэлийн үйлчилгээ авах хүсэлт гаргасан иргэдийн хүсэлтийг шийдвэрлэсэн хувь; | 100 | 100 | E Mongolia төрийн үйлчилгээний системээр дамжуулан шилжилт хөдөлгөөний бүртгэл 7 бүртгэж иргэдийн хүсэлтийг шийдвэрлэлээ. | |
| 2.4 | Алслагдсан сумаас эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх | -Эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж буй сумдын | 10 | 11 | Аймгийн төвөөс алслагдсан Алтай, Чандмань, Тонхил, Баян-Уул, Халиун, Цогт, Цээл, Бигэр, Эрдэнэ, Дэлгэр, Хөхморьт сумдын улсын бүртгэгчид | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | тоо; | | | 2025 онд эд хөрөнгийн эрхийн 294, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 132 үйлчилгээг тус тус үзүүлсэн байна. | |
| | | -Сумын улсын бүртгэгчийн хөтөлсөн эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тоо; | 400 | 800 | | |
| 2.5 | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Улсын бүртгэлийн багц хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөлд санал хүргүүлэх | Хуулийн төсөлд хүргүүлсэн саналын тоо | - | 4 | Улсын бүртгэлийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох хүрээнд Иргэний улсын бүртгэлийн хуулинд 2, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн тухай хуулинд 12, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн өөрчлөлтийн төслүүдэд 11 саналыг тус тус хүргүүллээ. | |
| 2.6 | Улсын бүртгэлийн “Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулах | “Нээлттэй өдөр” арга хэмжээг зохион байгуулсан тоо; | 5 | 5 | Тайлант хугацаанд “Нээлттэй өдөр” арга хэмжээг 6 удаа зохион байгууллаа.Уг арга хэмжээнүүдийн үеэр нийт 75 иргэн, 18 хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж 612 иргэнд тоон гарын үсэг олголоо. | |
| ЗОРИЛТ 3.УЛСЫН БҮРТГЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, НЭГДСЭН САНГИЙН НУУЦЛАЛЫГ ХАНГАН, ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫГ ХЭРЭГЖҮҮЛНЭ. | | | | | | |
| 3.1 | Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах | Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан хувь ; | 100 | 100 | 2025 онд Хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник техник, тоног төхөөрөмжид 25 удаа засвар үйлчилгээ, тохиргоог хийсэн. Бигэр, Гуулин, Шарга, Чандмань, Жаргалан, Цээл, Цогт сумдын сүлжээний төхөөрөмж (router)-ийн тохиргоо тогны хэлбэлзлээс шалтгаалан алдагдсаныг тохируулан хэвийн ажиллагааг хангаж, Хэлтсийн сүлжээний төхөөрөмжийг Fortinet router-оор сольж, тохиргоог | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | хийлгэн, хэвийн ажиллагаанд орууллаа. | |
| 3.2 | Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих. | Хяналт шалгалт хийсэн тоо; | 12 | 12 | 2025 онд өргөдөл, санал, гомдлын мөрөөр 44 удаагийн шалгалт хийсэн. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 407 бүртгэлд хяналт тавьж, 2 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 27 , эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 17, нийт 44 дүгнэлт гаргаж, биелэлтийг хангуулж ажилласан. | |
| 3.3 | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх | Шалган шийдвэрлэсэн зөрчлийн хувь; | 100 | 100 | Тайлант онд Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хүрээнд 181 гомдол мэдээллийг хүлээн авч, Прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэн, хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулж, 181 иргэнд 1.630.000 төгрөгөөр торгох шийтгэл ноогдуулсан. | |
| 3.4 | Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах | Архивын хадгалалт, хамгаалалтыг сайжруулахад хэрэгжүүлсэн ажлын тоо; | 10 | 10 | Архивын байранд гамшгийн үед ажиллах төлөвлөгөө, аврах гарцын схем зураг, архивыг эрсдлээс хамгаалах төлөвлөгөөг Хэлтсийн даргаар батлуулж хэрэгжүүлэн ажиллав. Төрөлжсөн болон байгууллагын архивт галын хор 3 ш, чийг дулаан хэмжигч 2 шинээр сольж байршуулан, орох гарах хаалга цонх зэргийг бүрэн камержуулсан. | |
| ЗОРИЛТ 4. АЙМАГ, ОРОН НУТГИЙН ТӨРИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАЖ, ХАМТЫН АЖИЛЛАГААГ ӨРГӨЖҮҮЛНЭ. | | | | | | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4.1 | Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай хамтран ажиллаж дэмжлэг авах | Санал, хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн ажлын тоо; | 1 | 2 | Аймгийн Засаг дарга, ИТХ-ын даргад хамтран ажиллах хүсэлтийг хүргүүлж Хэлтсийн гадна хайс, зогсоолыг засварлуулан тохижуууллаа.Мөн Хэлтсийн сургалтын танхимыг Аймгийн ИТХ-аас сургалтын тоног төхөөрөмжөөр хангахаар боллоо. | |
| 4.2 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” Үндэсний хөдөлгөөн болон Аймгийн хэмжээнд зарласан “108 сая мод тарих ая”-ны хүрээнд зохиогдож буй ажлын хэрэгжилтийг ханган ажиллах | Нийт тарьсан модны тоо; | 100 | 110 | Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, Говь-Алтай аймгийн Засаг даргын 108 сая мод тарих арга хэмжээний хүрээнд Шүтээний өндөрлөгийн бүсэд байрлах “Улсын бүртгэлийн төгөл”-ийн улиас, хайлаас зэрэг 180 модыг усалж арчлан, ургалт муутай байсан 20 модыг шинээр сольж, тарьлаа.Мөн Хэлтсийн байрны гадна хайсанд 20ш шинэс, монос зэрэг мод тарьж нөхөн сэргээлт хийлээ. | |
| ЗОРИЛТ 5. АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР ХЭРЭГЖҮҮЛНЭ. | | | | | | |
| 5.1 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах | Төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо; | 1 | 5 | “Авлигыг үл тэвчье” нээлттэй өдөрлөгийг 2025.04.14-ны өдөр Аймгийн ХХҮГ,Нийгмийн Даатгалын газартай хамтран зохион байгууллаа. Шүгэл үлээхийн ач холбогдлын талаар 2025.3-р сард 2 мэдээллийг бэлтгэж иргэдэд сурталчлан 53 иргэнд брошур тараан, авлигыг мэдээлэх 110 дугаарыг үйлчилгээний танхимын мэдээлэлийн самбарт байршуулсан.Мөн Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөлөөс 2025.07.01-ны өдөр зохион байгуулсан “Авлигыг үл тэвчье” | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Нээлттэй өдөрлөгт тус хэлтэс оролцож, иргэдэд авлигын хор хөнөөлийн талаар сурталчлан 19 иргэнд гарын авлага брошур тараан ажиллалаа. | |
| 5.2 | Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах | АТГ-аас бэлтгэсэн тв шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ, мэдээллийн самбарт байршуулж, олон нийтэд хүргэсэн тоо; | 5 | 5 | АТГ-аас бэлтгэсэн тв шторк 2, инфографик 1, цахим ном, гарын авлага зэргийг Улсын бүртгэлийн хэлтсийн цахим хуудаст байршуулж, олон нийтэд хүргэлээ. Мөн Авлигыг үл тэвчих үзлийг олон нийтэд төлөвшүүлэх ажлын хүрээнд 5 контентийг бүтээж Хэлтсийн нээлттэй вебсайтад байршуулан иргэдэд хүргэн ажилласан. | |
| ЗОРИЛТ 6. МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛНЭ. | | | | | | |
| 6.1 | Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийн чанарыг сайжруулах ажлын хүрээнд хийгдэж байгаа үйл ажиллагаатай уялдуулан холбогдох ажлыг зохион байгуулах | -Чадавхжуулах сургалтанд хамрагдсан албан хаагчийн тоо: | - | 13 | 2025.09.25-ны өдөр УБЕГ-ын ХЭБГ-аас зохион байгуулсан онлайн сургалтанд Хуулийн этгээдийн бүртгэл хөтлөх эрхтэй 11 бүртгэгчийг хамруулж, эцсийн өмчлөгчийн бүртгэлтэй холбогдох мэдээллийг сумуудын зарын групп дээр байршууллаа. | |
| | | -Зохион байгуулсан ажлын тоо: | - | 3 | | |
| ЗОРИЛТ 7. ЧАДАХУЙН ЗАРЧИМД СУУРИЛСАН ХҮНИЙ НӨӨЦИЙГ БҮРДҮҮЛЖ, АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАНА. | | | | | | |
| 7.1 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025-2028 онд хэрэгжүүлэх "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах | Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь; | 90 | 100 | Хууль зүй дотоод хэргийн сайдын санаачилгаар явуулсан "Хамгийн чухал нь" эрүүл мэндийн эрт илрүүлэг, үзлэг оношилгоонд Улсын бүртгэлийн хэлтсийн нийт албан хаагчид болон тэдний гэр бүлийн (насанд хүрсэн) гишүүн 65 хүн хамрагдав. | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Идэвхтэй амралт, явган аялалын арга хэмжээг 2025 оны 5, 9 саруудад 2 удаа зохион байгуулж бүх албан хаагч хамрагдсан.<br>-Аймгийн БТСГазартай хамтран албан хаагчдыг Мягмар гараг бүрт волейбол, сагсан бөмбөгөөр хичээллүүлж, 2025 онд спортын арга хэмжээг 3 удаа зохион байгуулав. | |
| 7.2 | Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалтанд албан хаагчдыг бүрэн хамруулах | Сургалтад хамрагдаж шалгалт өгсөн албан хаагчийн тоо; | 32 | 32 | УБЕГ-ын 2025.09.25-ны өдрийн 2-3/11116 тоотоор ирүүлсэн “Хичээл үзэж судлах” тухай албан бичгийн дагуу Удирдлагын академийн нэгдсэн сургалтын платформд байршуулсан Монгол бичгийн 3 шатны цахим хичээлийг Хэлтсийн 31 албан хаагч хуваарийн дагуу судалж сертификат авлаа. | |
| 7.3 | Улсын бүртгэлийн ерөнхий газрын 2025 оны “Сургалтын төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажиллах | Сургалтын төлөвлөгөөний биелэлтийн хувь: | 2 | 100 | Улсын бүртгэлийн хэлтсээс “ 2025 онд хэрэгжүүлэх сургалтын төлөвлөгөө”-г батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэ төлөвлөгөөнд тусгагдсан Үндэсний Монгол бичиг болон дохионы хэлний анхан шатны сургалт, Архив, бичиг хэргийн ажилтны сургалт, албан хаагчдын ажлын байрны сургалтын ажлууд бүрэн хэрэгжсэн. | |
| 7.5 | Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих | -Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь; | 100 | 100 | 2025 онд тус хэлтэст 911 албан бичиг ирсэн. Үүнээс 546 хариутай албан бичгийг хуулийн хугацаанд 100% шийдвэрлэн хариуг хүргүүлсэн. Үүнд: Хууль, хяналтын байгууллагад 356, АЗДТГ-т 71, УБЕГ-т 72, бусад байгууллагад 47 албан бичгийг хүргүүлсэн байна. 28 албан бичиг шийдвэрлэх шатандаа явж байна. Үүрэг чиглэл, шийдвэр, гадаад паспорт хүргүүлсэн гэх мэт хариугүй 365 албан бичгийг ирсэн. 228 албан бичгийг боловсруулан холбогдох албан | |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | тушаалтан, иргэдэд хүргэж ажилласан. Тус хэлтэст иргэн, хуулийн этгээдээс нийт 52 өргөдөл, санал, хүсэлт ирүүлснээс 50 өргөдлийг шийдвэрлэн иргэдэд хариуг хүргүүлсэн. 2 өргөдөл шийдвэрлэх шатандаа судлагдаж байна. | |

--oOo--